

ЗӨВЛӨХ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ ЗАРЛАЛ

2020 оны 12 дугаар сарын 16 -ны өдөр

1. “Монголросцветмет” ТӨҮГ нь МРЦМ/202008573 Туул голын гольдрол (MV-000175) талбайд хийгдэх геологи хайгуулын өрөмдлөгийн ажил гүйцэтгэх, үр дүнгийн тайлан боловсруулж ЭБМЗ-д хамгаалах зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулах гэж байгаа тул зөвлөхийн үйлчилгээ үзүүлэх хүсэлтэй этгээдийг мэдүүлгээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү зөвлөх үйлчилгээ нь Төв аймгийн Заамар сумын нутагт орших MV-000175 тоот алтны шороон ордын ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй талбайд геологи хайгуулын ажил хийж гүйцэтгэх, ажлын үр дүнгээр нөөцийн тодотгол тайланг бичиж Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд хамгаалах зөвлөх үйлчилгээний ажлыг хийж гүйцэтгэснээр ТӨҮГ-ын харъяа “Шижир алт” АҮ-ийн алтын нөөцийг нэмэгдүүлэх, үйлдвэрийн бүтээмжийг өсгөх болно.
3. Мэдүүлгээ ирүүлж буй зөвлөх хуулийн этгээд нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 зүйлд заасан шалгуур үзүүлэлт, шаардлагуудыг хангаж буйг нотлох дараах баримт бичгийг ирүүлнэ. Үүнд:
 - Байгууллагын ерөнхий танилцуулга
 - Аж ахуйн нэгжийн гэрчилгээний хуулбар /нотариатаар гэрчлүүлсэн/
 - Татвар, нийгмийн даатгалын газар, ШШГЕГ болон банкны тодорхойлолт зэргийг тендер зарласан өдрөөс хойшхи байдлаар/ ирүүлнэ.
 - Чадварыг нэмэгдүүлж, сайжруулах зорилгоор зөвлөхүүд түншлэлийн хэлбэрээр оролцож болно.
 - Сүүлийн 2 жил (2018, 2019 он) ижил төстэй ажил гүйцэтгэсэн туршлагын талаарх мэдээлэл, ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт эсвэл өмнөх үйлчлүүлэгчийн тодорхойлолт.
4. Сонирхсон этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 12 дугаар сарын 23–ны өдрийн 09 цагаас өмнө авч болох бөгөөд мэдүүлгийг 2020 оны 12 дугаар сарын 24- ний өдрийн 09 цагаас өмнө цахим худалдан авах ажиллагааны систем www.tender.gov.mn хаягаар ирүүлнэ.